



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/237

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төгрөг сумын Сайн төгрөг багийн малчин Оргодолын Нэргүйн тэмээн сүрэгт 2022 онд ингэ ихэрлэсэн тул малчинд хүндэтгэл үзүүлж батламж гардуулан, ингийг мөнгөн буйлаар буйллахад 1,400,000 (нэг сая дөрвөн зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх 1,400,000 (нэг сая дөрвөн зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0511